




МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

MNS 4585 : 2016



СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2016 он

Өмнөх үг

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1 : 2006, MNS 1-2 : 2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус Газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төсөл нь Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг БОНХАЖЯамны ахлах мэргэжлтэн Г.Хоролмаа боловсруулсан бөгөөд Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ын дагуу СХЗГ-ын мэргэжилтэн, Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны нарийн бичгийн дарга Г.Батзориг хянав.

Энэ стандартыг Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжиж, Стандартчиллын үндэсний зөвлөлөөр баталсан.

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ)
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар-13343 Ш/Х – 48
Утас: 263860, 266754 Факс: 976-11-458032
вэбсайт: www.masm.gov.mn
www.estandard.gov.mn
E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2016

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.040.01

Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	СТАНДАРТЧИВАЛ ХЭМЖИЛ ЗУИН ГАЗАР СТАНДАРТЫН БОЛОРСЛУУВАГНИЙ ОЛГОСОН ХҮЭС MNS 4585 : 2016
Air quality. General technical requirements	MNS 4585 : 2007-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 37 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2016 оны 07 дугаар сарын 08 –ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар болон аливаа орон байрны доторх орчны агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Энэхүү стандарт хот, суурин газрын агаарын чанар болон орон байрны доторх орчны агаарын чанарыг хянах, үнэлэхэд хамаарна.

2.2. Энэхүү стандартад зохих журам, аргачлалын дагуу тогтоосон ажлын байрны агаарын чанарын үзүүлэлт хамаарахгүй болно.

3. Норматив эшлэл

Энэ стандартад дараах стандартуудыг эш татсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас эш татаж хэрэглэнэ. Үүнд;

ДЭМБ, 85-хэвлэл, 2006, Агаарын чанарын зөвлөмж;

40 CFR part 50, 2006, Хүрээлэн байгаа орчны агаарын чанарын стандарт.

АНУ-ын Байгаль хамгаалах агентлаг, Агаар бохирдуулах бодисийн үзүүлэлт

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1

Агаарын чанар

Агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанар

4.2

Хүрээлэн байгаа агаар

MNS 4585 : 2016

байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хийн мандлын байгалийн төлвөөрөө байгаа хийн хольц

4.3.

Агаарын бохирдол

Хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсч бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэх

4.4.

Агаар бохирдуулах бодис

Бохирдлын аливаа эх үүсвэр, эсхүл түүнээс хаягдаж хүрээлэн байгаа агаар бохирдуулж байгаа физик, хими, биологийн болон цацраг идэвхит бодис, тэдгээрийн хольц

4.5.

PM10 тоосонцор

Агаар дахь 10 микрометрээс жижиг аэродинамик эквивалент диаметртэй тоосонцор

4.6.

PM2.5 тоосонцор

Агаар дахь 2.5 микрометрээс жижиг аэродинамик эквивалент диаметртэй тоосонцор

4.7.

Агаарын чанарын стандарт

Хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хүлцэх хэм хэмжээ

4.8.

Орон байрны доторх агаар

Гадна орчноос байгууламж хийцээр тусгаарлагдсан орон байрны доторх агаарын төлөв байдал.

5. Техникийн шаардлага

5.1. Агаар дахь бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физик нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг 1 дүгээр хүснэгтэд зааснаар тогтооно.

5.2. Агаарт байгаа түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бохирдсонд тооцож, агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.3 Хүрээлэн байгаа агаарын чанарыг агаарын чанарын индекс (АЧИ)-ээр үнэлж, өдөр тутам олон нийтэд мэдээлнэ.

1-р хүснэгт Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж
Химийн нөлөөлөл			
Хүхэрлэг хий (SO ₂)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	450 50 20
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	20 минутын дундаж 1 цагийн дундаж 8 цагийн дундаж	мкг/м ³	60000 30000 10000
Азотын давхар исэл (NO ₂)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	200 50 40
Озон (O ₃)	8 цагийн дундаж	мкг/м ³	100
Нийт тоосонцор	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	500 150 100
PM 10 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	100 50
PM 2.5 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	50 25
Хар тугалга (Pb)	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	1 0,25
Бенз-а-пирен (C ₂₀ H ₁₂)	24 цагийн дундаж	мкг/м ³	0,001
Физикийн нөлөөлөл			
Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дуу шуугиан - Өдрийн цаг (07-22 цаг) - Шөнийн цаг (22-07 цаг)	16 цагийн дундаж 8 цагийн дундаж	дБА	60 45

6. Орон байрны доторх агаарын чанарын үзүүлэлт.

6.1. Орон байрны доторх агаар дахь бохирдуулах бодис, физик нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хязгаарыг 2 дугаар хүснэгтэд зааснаар тогтооно.

2-р хүснэгт Орон байрны доторх агаар дахь бохирдуулах бодис, физик нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хязгаар

Үзүүлэлтийн нэр	Үнэлгээний нөхцөл	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хязгаар
Температур	Дундаж хэмжилтээр	Цельсийн градус	18-22
Агаарын урсгалын хурд	Дундаж хэмжилтээр	м/с	0,2- 0,4
Харьцангуй чийглэг	Дундаж хэмжилтээр	Хувь	30-60
Нүүрсхүчлийн хий (CO ₂)	24 цагийн дундаж	мг/м ³	1800
Гэрэлтүүлэг - Хүн байнга суудаг - Хүн байнга суудаггүй	Дундаж хэмжилтээр	Люкс	150-300 50-150

7. Агаарын чанарын шинжилгээ

7.1. Агаарын чанарын үзүүлэлтийг холбогдох норм, дүрэм, стандарт, арга аргачлалын дагуу тодорхойлно.

ТӨГСӨВ.